БАТЛАВ
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
..... Б.МЯГМАРНАРАН
2026 оны 03 дугаар сарын 04 өдөр

"ЦАХИМ АЙМАГ-УХААЛАГ ХОТ" ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

Д/д	Агуулга	Тайлбар, тодорхойлолт
1	Үйлчилгээний нэр	"Цахим аймаг - Ухаалаг хот" зөвлөмжийн хэрэгжилтийг хангах
2	Захиалагч байгууллага, газар, хэлтсийн нэр	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Дижитал шилжилт, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар.
3	Үндэслэл, хэрэгцээ шаардлага	**Эрх зүйн үндэслэл:** Монгол Улсын Их Хурлын 2020 оны ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.2.4 дүгээрт "Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд үзүүлэх төрийн үйлчилгээг тодорхойлж, шат дамжлагыг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.", 9.3.9 дүгээрт "Хиймэл оюун ухаанд суурилсан ухаалаг системийн дараагийн үе шатны технологийг хот байгуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ." 9.4.7 дугаарт "Мэдээллийг цахимжуулж, иргэдэд төрийн үйлчилгээг цогц байдлаар, цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бий болгож хэрэгжүүлнэ." 9.4.16 дугаарт "Цахим засаглалын технологийг бүх түвшинд бүрэн хэрэгжүүлж, авлига хүнд сурталгүй төрийн үйлчилгээг төлөвшүүлнэ." гэж тус тус заасан. Мөн Монгол Улсын Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Хот, тосгоны удирдлага нь хот, тосгоны чиг үүргийг хэрэгжүүлэхэд харилцаа холбоо, мэдээллийн технологийг дараах хэлбэрээр ашиглана: 14.1.1.инновац, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, юмсын интернэт зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;

		14.1.2.шийдвэр гаргахаас өмнө тухайн шийдвэрийг цахим орчинд урьдчилан загварчилж, үр дүнг тооцоолох; 14.1.3.дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд зохицуулалтын сэндбокс орчинд туршиж, оршин суугчийн саналыг авах; 14.1.4.харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд бүтэц, мэдээллийн системийг бий болгох, түүний тасралтгүй, найдвартай байдал болон кибер аюулгүй байдлыг хангах, мэдээллийг саадгүй солилцох боломжийг бүрдүүлэх; "14.1.5.хотод цугларсан мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл болгон олон нийтэд ил тод байршуулах." гэж хуульчилсан. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 5.3 дахь зорилт, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.2.2, 4.3 дахь хэсэгт заасан зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 108 дугаар тогтоолоор "Цахимаар нэн тэргүүнд" бодлогын зөвлөмжийг баталсан ба тус тогтоолын 2-т: "Цахимаар нэн тэргүүнд бодлогын зөвлөмжийг бүх шатны төрийн байгууллагад сурталчлан таниулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан, тайлан, мэдээллийг нэгтгэн жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал нарт тус тус даалгасан. **Өнөөгийн нөхцөл байдал, төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага:** Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/53 дугаар тушаалын хавсралтаар "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг баталж, тус зөвлөмжийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанд танилцуулан, Засгийн газрын 25 дугаар тэмдэглэлийн XIII.10-д "Цахим аймаг бодлогын зөвлөмж"-ийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахыг ЦХИХХ-ны сайдад даалгасан ба тус үүргийн дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам 2023 онд 21

		аймагт ажиллаж, аймаг тус бүрийн цахим шилжилтийн талаар авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээ, хүрсэн түвшин, тулгамдаж буй асуудал зэргийг тодорхойлж, аймгийн удирдлага, төрийн албан хаагчид, орон нутгийн иргэд, анхан шатны байгууллагуудыг судалгаанд хамруулан ажилласан. Судалгааны үр дүнд аймгуудын дундаж хувь нь 41 хувь гэж үнэлэгдсэн ба 2024 онд төр, хувийн хэвшлийн түшлэлийг сайжруулах, иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх, цахим шилжилтийн талаар мэдлэг, ойлголт өгөх чиглэлээр "Цахимд хэвшье" аяныг 21 аймагт харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Мөн 2025 онд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас цахим шилжилтийг тодорхойлох судалгааг Аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан бөгөөд аймгуудын дундаж хувь 51 хувьтай, иргэдийн цахим ур чадварын түвшин улсын хэмжээнд дунджаар 64 хувьтай гэж үнэлэгдсэн. Иймд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн "Арга хэмжээ зохион байгуулах тухай" А/26 дугаар тушаалаар "Цахимаар нэн тэргүүнд" бодлогын зөвлөмжийг нийслэл, орон нутагт сурталчлан таниулах, салбар хоорондын хамтан ажиллагааг дэмжиж, идэвхжүүлэх "Олон талт арга хэмжээ"-г 2026 онд зохион байгуулахаар шийдвэрлэсний дагуу "Цахимаар нэн тэргүүнд" болон "Цахим аймаг" бодлогын зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хангах, төрийн байгууллагын албан хаагчид, иргэнд асуудлыг нэн тэргүүнд цахимаар шийдвэрлэх хандлага, чадварыг суулгах арга хэмжээг тогтмол зохион байгуулж, цахим шилжилтийг эрчимжүүлэх хэрэгцээ, шаардлага тулгараад байна.
4	Зорилго	"Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан "Цахимаар нэн тэргүүнд" бодлогын зөвлөмжтэй уялдуулан хэрэгжүүлж, аймаг, орон нутгийн цахимжилтыг эрчимжүүлэх, олон нийтэд сурталчлах, салбар хоорондын мэдээллийн системийн уялдааг хангах, төлөвлөлт, хэрэгжилтийг оновчтой удирдахад оршино.

5	Гүйцэтгэх ажил	Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь захиалагчтай харилцан санал солилцож дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: **Гүйцэтгэх ажил 1.Брэндбүүк хөгжүүлэх:** 1.Ажлын даалгаврын зорилготой уялдуулан Брэндбүүк (Алсын хараа, зорилго, үнэт зүйлс, брэндийн философи болон олон нийт, зорилтот хэрэглэгчдэд чиглэсэн мессеж, уриа үг тодорхойлох) боловсруулах; 2.Лого боловсруулах (үндсэн лого дизайн, утга, бэлгэдлийн тайлбар, хувилбарууд /өнгөт, хар цагаан, icon хэлбэр/, лого ашиглах заавар /хэмжээ, зай, буруу ашиглалтын жишээ/; 3.Өнгөний стандарт /үндсэн өнгө, туслах өнгө, RGB / CMYK /код, дижитал болон хэвлэлийн хэрэглээний стандарт/; 4.Фонт ба бичгийн хэв /гарчгийн фонт, үндсэн текстийн фонт, Монгол болон англи текстэд ашиглах стандарт, гарчиг, дэд гарчиг, текст/; 5.Дүрслэлийн загвар; 6.Цахим хэрэглээний загвар /фэйсбүүк постер загвар, баннер, сошиал медиа ковер, танилцуулга загвар(.ppt), инфографик загвар/; 7.Сурталчилгааны материалын загвар /постер, баннер, хэвлэлийн материал (брошур, товхимол), самбар. **Гүйцэтгэх ажил 2. Олон нийтэд хүргэх, түгээх** 1.Эх бэлтгэх /30 ширхэг/; 2.Контент бүүст хийх /2 удаа/; 3.Зураг авалт /1 аймагт/; 4.Олон нийтэд мэдээллэх /1 аймаг, 10 сайт ярилцлага, 1 телевиз ярилцлага, 1 телевизээр шууд дамжуулалт хийх/. **Гүйцэтгэх ажил 3. Видео контент үйлдвэрлэлийн үйлчилгээ** 1.Сошиал медиа рийлс /10 ширхэг/; 2.Өмнө ба дараа өөрчлөлтийг харуулсан видео /2 ширхэг/; 3.Сошиал сүлжээнд ашиглах богино видео контент /1 ширхэг шторк/. **Гүйцэтгэх ажил 4. Иргэд олон нийтэд таниулах сургалт, хэлэлцүүлэг** Сонгосон 1 аймагт бодлогын зөвлөмжийг сурталчлан таниулах арга хэмжээг захиалагчийн 40 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй баг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.

6	Ажил гүйцэтгэх хугацаа	**Эхлэх хугацаа:** Гэрээ байгуулсан өдрөөс эхэлнэ. **Дуусах хугацаа:** Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хуанлийн 10 хоног (хуулиар тогтоосон амралтын өдрийг тооцохгүй)-т гүйцэтгэнэ. Захиалагч, үйлчилгээ үзүүлэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу Ажлын даалгаварт туссан ажлыг бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгснөөр гэрээ дуусгавар болно.
7	Хяналт, шалгалт	Үйлчилгээ үзүүлэгч нь төслийн хэрэгжилтийн явц, чанарыг хянуулах зорилгоор батлагдсан хуваарийн дагуу ажлын явцын тайланг Захиалагчид тогтмол гаргаж өгнө.
8	Хүлээлгэн өгөх материал	Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү ажлын даалгаврын 5-д заасан ажил тус бүрийг гүйцэтгэсэн талаарх тайланг цаасан болон цахим хэлбэрээр 3 хувь үйлдэж, гэрээнд заасан хугацаанд дуусган, акт үйлдэж, захиалагчид хүлээлгэн өгнө.
9	Онцгой нөхцөл	Ажлын ерөнхий зорилго болон хүрээг өөрчлөхгүйгээр харилцан зөвшилцсөний үндсэн дээр энэхүү Ажлын даалгаварт өөрчлөлт оруулж болно.
10	Үр дүн	Захиалагчид хүлээлгэн өгөх үр дүн: 1.Брэндбүүк /тайлангийн баримт бичигтэй/ 2.Олон нийтэд түгээсэн ажлын тайлан /эх бэлтгэх /30 ширхэг/, контент бүүст хийсэн тайлан /2 удаа/, зураг авалтын тайлан /1 аймагт/, олон нийтэд түгээн дэлгэрүүлсэн тайлан /10 сайт ярилцлага, 1 телевиз ярилцлага, 1 телевизээр шууд дамжуулалт хийх/ 3.Видео контент үйлдвэрлэлийн үйлчилгээний тайлан цаасан болон цахим хэлбэрээр /сошиал медиа рийлс /10 ширхэг/, өмнө ба дараа өөрчлөлтийг харуулсан видео /2 ширхэг/, сошиал сүлжээнд ашиглах богино видео контент /1 ширхэг шторк/.

ХЯНАСАН:

ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ, ИННОВАЦЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЦЭНГҮҮНЖАВ

БОЛОВСРУУЛСАН:

СТРАТЕГИ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ Ч.БОЛОР-ЭРДЭНЭ

ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ, ИННОВАЦЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ЛХАГВАДОЛГОР